



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ахмад настны үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон 22 нэр төрлийн нийт 11,620,800.00 /арван нэгэн сая зургаан зуун хорин мянга найман зуун/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг /худалдахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр/ улсын төсөвт төвлөрүүлэх;

2.4.Хөрөнгийг акталж буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;

2.5.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН


ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



0000043

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн
47...
дугаар албан бичгийн хавсралт



Ахмад настны үндэсний төвийн үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй актлах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Бүгд үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Мухлагийн байр	2000	1	221,400.00	221,400.00	221,400.00	0.00
2	Блоккийн машин	2012	1	1,200,000.00	1,200,000.00	1,200,000.00	0.00
3	Гүйлтийн зам	2009	1	2,250,000.00	2,250,000.00	2,250,000.00	0.00
4	Зурагт /SHARP/	2008	1	203,000.00	203,000.00	203,000.00	0.00
5	Зурагт /PHILIPS/	2009	1	145,000.00	145,000.00	145,000.00	0.00
6	Зурагт /BSB/	2009	1	215,000.00	215,000.00	215,000.00	0.00
7	Зурагт /SHARP/	2009	2	100,000.00	200,000.00	200,000.00	0.00
8	Компьютер /CCIVO/	2009	2	150,000.00	300,000.00	300,000.00	0.00
9	Компьютер /Dell/	2009	1	500,000.00	500,000.00	500,000.00	0.00
10	Сэгсрэгчтэй угаалгын машин	2008	2	1,600,000.00	3,200,000.00	3,200,000.00	0.00
11	Угаалгын машин	2012	1	200,000.00	200,000.00	200,000.00	0.00
12	Хөлдөөгч	2009	1	260,000.00	260,000.00	260,000.00	0.00
13	Хөргөгч /6-н хаалгатай Хятад 1тн/	2009	1	1,000,000.00	1,000,000.00	1,000,000.00	0.00
14	Хөргөгч	2012	1	245,000.00	245,000.00	245,000.00	0.00
15	Хөргөгч	2009	1	200,000.00	200,000.00	200,000.00	0.00
16	Мужааны хөрөө	2008	1	300,000.00	300,000.00	300,000.00	0.00

17	Будаа агшаагч	2012	1	130,000.00	130,000.00	130,000.00	0.00
18	Талхны хэв	2011	14	5,500.00	77,000.00	77,000.00	0.00
19	Өсгөгч	2009	1	180,000.00	180,000.00	180,000.00	0.00
20	Яригч	2009	1	300,000.00	300,000.00	300,000.00	0.00
21	Даралтын аппарат	2014	1	58,000.00	58,000.00	58,000.00	0.00
22	Өргөө хивс	2004	1	236,400.00	236,400.00	236,400.00	0.00
	Нийт дүн		38		11,620,800.00 /арван нэгэн сая зургаан зуун хорин мянга найман зуун/	11,620,800.00 /арван нэгэн сая зургаан зуун хорин мянга найман зуун/	0.00